



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/168

Мөрөн сум

Салбар комисс шинэчлэн байгуулах
Тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1, 42 дугаар зүйлийн 42.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор баталсан "Хөгжлийг бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс"-ын дүрмийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг дараах бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай.

Дарга: Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

- Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн их эмч
- Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн мэдрэлийн их эмч
- Боловсрол шинжлэх ухааны газрын Тусгай хэрэгцээт боловсрол, хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тусгай хэрэгцээт боловсролын багш

Нарийн бичгийн дарга:

- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Салбар комиссын үйл ажиллагааг бэхжүүлэн, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг шинэ шатанд гарган үр дүнтэй ажиллахыг Салбар комиссын даргад үүрэг болгосугай.

3. Тус захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/174 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ШИДЭРБАЯСГАЛАН